

МОНГОЛ ХӨӨМИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙГ АВИАЗҮЙН ХЭЛЛЭГИЙН ҮҮДНЭЭС АЖИГЛАН ТАЙЛБАРЛАХ НЬ

Мөнхжаргалын Амаржаргал

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургуулийн докторант,
Улаанбаатар, Монгол улс
amaraamaa88@gmail.com

Хураангуй: Ардын урлагийн төрөл зүйл, арга барил, илэрхийллийн өвөрмөц хэлбэр, хоорондын уялдаа холбоо, хэвшмэл хэв загвар, нийгэм соёлын өөрчлөлт зэргийг нарийвчлан судлах хэрэгцээ шаардлага бидний өмнө тулгарч байна. Энэ өгүүллээр ардын хөгжим судлал гэх том ай савын нэгэн бүрэлдэхүүн болох өгүүлэх эрхтний шүтэлцээт урлаг (цаашид “аман хөгжимдүүрийн урлаг” гэх) тэр дундаа хөөмийн урлагийн илэрхийлэл, түүний ангиллын асуудлыг орчин цагийн монгол хэлний авиазүйн хэллэг (articulatory)-ийн үүднээс ажиглах, тайлбарлах боломжийг эрэлхийлж, ангиллын загварчлал хийх оролдлогын үр дүнгээ мэдээлэхийг зорилго болгов. Эл судалгаанд нэр томъёогоо “хөөмий” хэмээн бичсэн нь “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” болон “Хөгжим” соёл урлагийн тайлбар толийг баримтлав.

Түлхүүр үг: артикуляц, төрөл ойлголт, ангиллын загвар

EXPLAINING THE TYPE OF MONGOLIAN "KHOOMII" FROM THE PHONOLOGICAL ARTICULATION'S POINT OF VIEW

Amarjargal Munkhjargal

Doctoral student of School of Music Art, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
amaraamaa88@gmail.com

Abstract: We are faced with the need to study in detail the types and methods of folk art, the unique forms of expression, the connection between them, stereotypes, and social and cultural changes. In this article, I aimed to search for an opportunity to explain the expression art of the narrating organ, which is a part of the big field of folk musicology, especially of the throat singing art, and classification from the perspective of the phonological articulation of the Mongolian language and to report the results of the attempt to model the classification. In the study, the term “Khuumii” was written in accordance with the “Regulated Dictionary of Mongolian Spelling Grammar” and the “Music” volume of the Dictionary of Culture and Art.

Keywords: articulation, concept of type, classification model

Оршил

Нүүдэлчин ард түмэн ахуй байдлын ертөнцийг гоо сайхнаар эдэлж эрхэмлэн, байгаль цаг уураа шинжиж яруу сайхныг үзэж, сонсох явцдаа ерөөл магтаал, дуу хөгжим, бүжиг наадам, жүжиг наадгай, ур дарх, оёдол үйл мэт ардын урлагийн арвин өв санг үүсгэн бий болгосон. Харин эдгээрээс ардын хөгжмийн өвийг эдүгээгийн залуучууд, хойч үед өвлүүлэх, үнэ цэнийг ойлгуулах, хүмүүжил сэтгэлгээний соёлд сургах, сурталчлах, судлан шинжих явдлыг чухал болохыг судлаач Ж.Бадраа (2017) онцлон тэмдэглэсэн байдаг. Тэгвэл өнөө цагийн залуусын дийлэнх нь ардын урлагийг хуучны, хоцрогдсон мэтээр хүлээн авах болсон. Үүнтэй уялдан уран бүтээлчид орчин цагийн соёлын хандлагад түшиглэн, эдүгээгийн хүн төрөлхтний сонирхол таашаалд нийцүүлэн, техник технологийн оролцоог эрхэмлэн, орчин үеийн урсгал чиглэлийн өнгө аясаар уран бүтээл туурвих хандлага ихэссэн. Энэ нь нэг талаар сайшаалтай ч язгуур болон уламжлалт шинжийг балартуулах сөрөг муу талтай байж болохыг анхаарууштай.

Хүн өөрийн хүрээлэн буй орчин, байгаль, цаг уурын өөрчлөлт, ан амьтдын амь зогоон амьдрах хэв маяг, байгалийн үзэгдэл, элдэв амьтнаас гарах дуу чимээ, үйл хөдлөлийг харах, сонсох, хүртэх хэлбэрээр танин мэдсэн зүйлсээ өөрийн тархиндаа боловсруулан оюун дүгнэлт хийж, түүнийгээ бие эрхтэн болон бусад эд хэрэглэл, зэмсгийн оролцоотойгоор дамжуулан илэрхийлэх байдлын үр дүн мэт нь урлагийг төрөлжүүлэн харах, судлах боломжийг бидэнд олгодог.

Хөөмийн гарал үүсэл, төрөл зүйл, хөөмийлөх арга барил, илэрхийллийн тухайд судлаач, сонирхогчид өөрийн байр сууриа янз бүрээр илэрхийлсээр ирсэн. Ялангуяа хөөмийн төрөл зүйлийн тухайд нэг хүний дэвшүүлсэн санааг нөгөө нь баяжуулах, эсвэл үгүйсгэх байдлаар цоо шинэ ангилал гаргасан мэт хоёр зүйлийн хандлага давамгайлах байдалтай явж иржээ гэж хэлж болно. “1950-аад оноос хойш хөөмийн урлаг эх орон даяар түгэн дэлгэрч, тоочин унших магтаалын шинжтэй...” (Энэбиш, 2007, 273) байснаа эдүгээ арга техник баяжиж, судалгаа, сургалт, уран бүтээл улам гүнзгийрсээр байна. Тухайлбал, судлаач Ж.Бадраа “Монгол ардын хөгжим” номдоо хөөмийн ангиллыг уянгын болон хархираа хэмээн хоёр үндсэн төрөл¹-тэй хэмээн үзсэн бол, хөөмийн өвлөн уламжлагчид сонин содон дуу авиаг бүтээж хөөмийлөх, туршин судлах зэргээр өөр өөрсдийн арга техникт тулгуурлан хэд хэдэн нэр төрөл болгон оноон нэрлэх хандлага ихэссэн. Түүний түгээмэл жишээнд хөөмийч Д.Сундуй², Р.Даваажав³, Т.Ганболд⁴, Э.Тойвгоо⁵ Э.Сандагжав⁶,

¹ Ж.Бадраа: Уянгын хөөмий (хамрын, тагнайн, төвөнхийн, багалзуурын, цээжний, хэвлийн), хархираа хөөмий (суурьт эгшиг голлон доод чалхад дуурьсах)

² Д.Сундуй: Шингэн исгэрээ, хархираа хөөмий

³ Р.Даваажав: Тагнайн, багалзуурын, үелзүүр хөөмий

⁴ Т.Ганболд: Хархираа, шингэн исгэрээ, задгай, хамрын хөөмий

⁵ Э.Тойвгоо: хархираа, хамрын, бойвлох, ташилдах, чичиргээ хөөмий

⁶ Э.Сандагжав: Исгэрээ, шахаа, хосмолжин, хархираа, цуур хөөмий, хамрын хөөмий

Д.Цэрэндаваа⁷, Б.Одсүрэн⁸ нарын 2-13 янзаар ялган нэрлэснийг дурдаж болно. Хожим нь доктор Л.Хэрлэн эрдмийн зэрэг горилсон нэгэн сэдэвт бүтээлдээ хүний өгүүлэх эрхтнээр үйлдэгдэх авиа бүтэх орон хийгээд авиа үүтгэгч хийн хүрд, дуун хүрдтэй холбож “хөөмий төст авианаас уянгын хөөмий, хархираа хөөмий” (Хэрлэн, 2010, 118) гэсэн төрлөөс цааш салаалан задрах талаар авч үзсэн нь Ж.Бадраагийн дэвшүүлсэн саналтай нийлж байна. Ялгагдах онцлог нь “хөөмий төст авиа”-нд цуурай авиа⁹, хоолойн шахаа¹⁰, унзад хоолой¹¹-н авиа, бахлуурын дуу¹², цоорын дуу¹³, цуур хөгжмийн суурь өнгө¹⁴, тууль магтаалын хоолойн шахаа¹⁵ зэргийг бүхлээр нь хамруулсан байдаг.

Судалгааны арга зүй

Аливаа зүйлд ангилал хийхэд дүрс ба төрөл ойлголт, ерөнхий ба тусгай ойлголтын талаар логикийн үүднээс ялгаж салгаж ойлгох шаардлагатай байдаг. Харин хөөмийн ангиллыг логик ойлголтын үүднээс ажиглахад ерөнхий ба тусгай ойлголтыг нийтлэг шинжтэй мэтээр нэг түвшинд зэрэгцүүлэн авч үзсэн хандлага түгээмэл ажиглагдаж байна. Учир иймээс хөөмийд суралцах үеийн анхны дасгал сургуулилт, түүнд хэрэглэдэг авиа эгшгийн оролцоог ажигласны үндсэнд орчин цагийн монгол хэлний зарим эгшиг, гийгүүлэгчийн өгүүлэгдэх байдлыг, ялангуяа хэлний байрлалын тухайд сонирхон үзэх шаардлага гарав. Мөн хөөмийлөх үеийн хэлний байрлалыг монгол хэлний авиазүйн үүднээс зарим эгшиг, гийгүүлэгчийн хэллэг дэх хэлний байрлалтай зэрэгцүүлэн харьцуулах замаар ажиглалтын үр дүнгийн төсөөллөө системийн онолын үүднээс нэгтгэж хөөмийн ангиллын асуудалд өөрийн саналаа мэдээлэв.

Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг

Судлаач, хөөмийчдийн ангиллын асуудалд шинэ шийдэл хайх боломжийг эрэлхийлж, хэл шинжлэлийн ухааны нэгэн салбар авиазүйн гол объект болох дуу

⁷ Д.Цэрэндаваа: Авиа гаргах дасгал, харгилах буюу хархирах, уруулын, тагнайн, хамрын, багалзуурын, цээжний, хосмолжин

⁸ Б.Одсүрэн: Шулуун цуурай, үелсэн цуурай, исгэрээтэй цуурай, хамрын цуурай, нарийн исгэрээ, дандилдах, шулуун хархираа, туйлын харгиа, суурь дамжсан харгиа, уруулын, хирхрээ, доргио, авиа гаргах дасгал

⁹ Цуурай авиа: Багалзуурын хөндийд буюу хөөмийн эрхтнүүдийг шахаж, агшаах маягаар тусгай булчигнуудын үрээр агшиж сулрахад үүссэн дуу анир (Хэрлэн, 2010, 117)

¹⁰ Хоолойн шахаа: Багалзуур хоолой орчмын булчигнуудыг чангаруулж дуутарах үеийн хөөмий төст авиа

¹¹ Унзад хоолой: Бурханы шашны хурал номыг эхлүүлдэг унзад ламын шахмал бүдүүн хоолойг хэлнэ.

¹² Бахлуурын дуу: Амьсгаа түгжилт нэг их шаардахгүйгээр хоолойг шахаж, төвөнх доргнулан үүсгэх цоорын дуу маягийн авиа (Одсүрэн, 2010)

¹³ Цоорын дуу: Өвөр монголын ард түмний дунд хөөмий төст авиа эгшиглэгээгээр доод суурь өнгийг эгшиглүүлэх явцад ургын дууг дуулах нэгэн хэлбэр (Хэрлэн, 2010, 130)

¹⁴ Цуур хөгжмийн суурь өнгө: Цуур хөгжмийг үлээх үед дууны хөвчийг сул доргиоход үүсэх хархираа төст авиа

¹⁵ Тууль магтаалын хоолойн шахаа: Тууль хайлах, магтаал хэлэхэд багалзуур хоолой болон төвөнхийн булчигнуудыг шахах маягаар дууны хөвчийг сул доргиож үүсгэх авиа (Хэрлэн, 2010, 129)

чимээг судлах аргын нэгэн хэлбэр болох артикуляц¹⁶ (хэлтэг)-ын үүднээс сонирхон үзлээ. Орчин цагийн шинжлэх ухаанд хэлний авиаг дотоод мэдрэхүй, эрчим энергийн талаас судлах шинэ хандлага бий болж Ж.Санжаа, Ж.Надмид (2008) нар хэлний авиаг сонсгол зүй (акустик-бие мах бодийн), өгүүлэхүй (артикуляц-биологийн), үүрэг (функциональ-хэл шинжлэлийн) дотоод мэдрэхүй-био энергийн ойлголт талаас нь судалсаар байна.

Эдгээрээс хэл, уруул, шүд, тагнай гэх авиа үүсгэхэд голлон оролцож буй өгүүлэх эрхтний оролцоог чухалчилж, хөөмийн авиа эгшгийн дуурьсалтай харьцуулан үзэхэд дараах зүйлс ажиглагдав.

Хөөмийн урлагийг заан сургах үйл явцын анхны хичээлд “а, э, и, о, у, ө, ү” монгол хэлний эгшиг авиануудыг багалзуур хоолой орчимд шахах байдлаар дуугаргах оролдлого хийлгүүлдэг. Дасгал сургуулилтын явцыг ажиглахад “а, и, у” эгшиг авианы дуугаралтаас хөөмийн хос эгшгийн цуурай авиа илүү тод сонсогддог. Түүнчлэн “и” эгшиг авианаас хөөмийн дээд өнгө, “у, ү” эгшиг авианаас доод өнгө илүүтэй сонсогдохыг сургалтын явцаас ажиглаж болно. Харин эгшгээр амилуулсан гийгүүлэгч авианы дасгалын явцаас “а-л, э-л, и-л, о-л, у-л, ө-л, ү-л”, “ла-лэ-ли-ло-лу-лө-лү”, “ра-рэ-ри-ро-ру-рө-рү” гэх зэрэг хэлний идэвхтэй хөдөлгөөний оролцооноос хамаарах авианаас хөөмийн давхар эгшгийн дуурьсал илүү тод сонсогдох нь ч бий. Эдгээрийг хүний ерийн чих ялгаж сонсох боломж хомс учраас нарийн ялгааг техник төхөөрөмжийн оролцоотойгоор шийдвэрлэх боломжтой. Гэвч бид дасгал сургуулилт болон хөөмийлөх үеийн хэлний хөдөлгөөнийг ажиглахад хөөмийн дасгал сургуулилтад амаа нээж дуугарах үед эгшиг авианууд, амаа хааж дуугарах үед “м” [m] төст авиа, ам нээлттэй боловч хэлний үзүүрийг хатуу тагнай тийш байрлуулан дуугарах үед “л” төст авиа сонсогдоно. Эдгээрээс үүдэж хөөмийн урлагийг төрөлжүүлж нэрлэх асуудлыг орчин цагийн монгол хэлний авиазүйн хэллэгтэй холбон үзэх санаа төрж “а”, “л”, “м” эгшиг болон гийгүүлэгч авианы өгүүлэх үеийн рентген зураглалыг сонирхон үзсэн болно.

Монгол хэлний “а” авиаг үүсгэх үед уушгинаас түрэгдэн ирсэн хийн урсгал нэлээд хүчтэй бөгөөд чөлөөтэй урсаж гарна. Энэ үед хэл бүхэлдээ сул байдалтай, хэлний үзүүр хэсэг үл ялиг доод буйланд хүрсэн, харин хэлний уг хэсэг бага зэрэг агшиж амны хөндийн зай уужим болсноор сая “а” авиа чөлөөтэй зөв дуудагддаг (Цолоо, 1967, 20) байна.

Харин “уушгинаас гарсан хийг цагаан мөгөөрсөн хоолойгоор дамжуулан түлхэхэд дууны хуурамч хөвчний булчин чангарч хөөмийн цуурай авиа үүснэ” (Загд-Очир, Даваасүрэн, 2020, 105). Энэ аргаар “а” авиаг үүсгэх явцад хэлний хөдөлгөөн ерөнхийдөө үндсэн байрлалд хэвээр боловч хэлний үзүүр, дунд, угийн булчин, мөн хүүхэн хэлний булчин тэр чигтээ чангарсан байдалтай байна (Зураг дээр ташуу зураасаар тэмдэглэв). Харин зулай нимгэн хэсгээр үл ялиг хотойлгож цуурайг үүсгэнэ. Үүнийг монгол хэлний “а” эгшиг авианы өгүүлэх үеийн рентген зураглал дээр төсөөлөн зураглав (Зураг 16).

¹⁶ Articulatory: Өгүүлэх эрхтний ажиллагаа (<https://bolor-toli.com/>)
Артикуляция (articulate): а. Тод дуудлага: Эгшгийг дуурьсгах арга барил, зарчим (Жанцанноров, 1996, 14), б. Хэллэг: Хөгжмийн эгшгийг бүхий л төвшинд хэсэглэх болон холбох замаар легаго, стаккато-ийн олон хэлбэрүүдийг ашиглан илэрхийлэгч урлаг (Оюунбадрах, 2016, 106)



Зураг 1.

а. Монгол хэлний “а” эгшигийг өгүүлэх үеийн хэлний байрлалын рентгений бүдүүвч

б. Хөөмийн шахаагаар “а” эгшигийг үүсгэх үеийн хэлний байрлалын төсөөлөл¹⁷

Үүнчлэн “а” авианаас хэлний үзүүрийг тагнай тийш босгон байрлуулах үед хөөмийн исгэрээ илүү тодорч сонсогдох ба энэ нь орчин цагийн монгол хэлний “л” гийгүүлэгч авиатай төстэй боловч хөндий сонсогдоно. Энэ авиалбарын сонсогдох байдлыг “лх” эсвэл буриад ястны “х” гийгүүлэгч авиаг зөөлрүүлэн дуудах “h” авиаг ашиглан “лh” гэж ч тэмдэглэж болмоор санагдана.

“Л” гийгүүлэгч авиа нь хэлний урдуурх сул авиалбар бөгөөд үүнийг хэлэх үед хэлний үзүүр хэсэг үүдэн шүд буйланд хамжиж, уушгинаас түрэгдэн ирсэн хийн урсгал нь хэлний хоёр хажуугаар шүргэн гардаг онцлогтой” (Цолоо, 1967, 24) бол, “лh” хөөмийн авиа мөн үүнтэй ижил боловч хэлний байрлал үл ялиг арагш байрладгаар ялгаатай. Үүнийг дараах зураг дээр төсөөлөн зураглав (Зураг 2 а, б)



Зураг 2.

а. Монгол хэлний “л” гийгүүлэгчийг хэлэх үеийн хэлний байрлалын рентгений бүдүүвч

б. Исгэрээ хөөмийг эгшиглүүлэх үеийн хэлний байрлалын төсөөлөл

Дээрх зургаас хэлний байрлалыг харьцуулан харвал исгэрээ хөөмийн ая эгшгийг дуурьсгах үед хэлний үзүүр тагнай тийш арагш матирч, хэл зулай нимгэн хэсгээр бага зэрэг хонхойх үед тагнай, хэлний завсарт цуурай үүсгэх бичил хөндий үүснэ. Тэр бичил хөндийд хэлний хөдөлгөөнийг хөгжмийн долоон эгшгийн дараалалд маш нарийн мэдрэмжээр хөдөлгөж аялгуу дуурьсгана. Хэлний хөдөлгөөнийг хэрхэн зөв удирдах тал дээр хөөмийн багш Б.Одсүрэнгийн заах

¹⁷ Орчин цагийн монгол хэлний авиа зүй, зөв бичих зүйн асуудлаар мэргэшсэн хэл бичгийн шинжлэх ухааны доктор С.Мөөмөөгийн зааварчилгаа, түүний монгол хэлний аялгын тогтолцооны зарчимд тулгуурлан төсөөлөн зураглав (2008.04.17).

арга барилд хэрэглэгддэг нэгэн өвөрмөц хэлбэрийг ойлгомжтой болгох үүднээс зураглан үзүүлэв.



Зураг 3. Хөөмийн аялгууны хэлний хөдөлгөөний дүрслэл
("Дөрвөн уул" дууны жишээгээр)¹⁸



Зураг 4. "Дөрвөн уул" дууны аялгууг суурь өнгийн хамт тэмдэглэсэн байдал

Харин багалзуур болон төвөнх орчимд шахах, чичирхийлэх үйлдэл өөрчлөгдөхгүй, зөвхөн амыг хааж хамрын хөндийгөөр хөөмийн дуурслыг гадагшлуулах явцыг хөөмийч судлаачид хамрын хөөмий хэмээн нэршиж ирсэн. Үүнийг орчин цагийн монгол хэлний "м" гийгүүлэгч авиатай харьцуулж болмоор байна.

"М" гийгүүлэгчийг хэлэх үед дээд доод уруул хамжигдаж уушгинаас түрэгдэн ирсэн хийн урсгал хамрын хөндийгөөр сулхан урсан гардаг" (Мөөмөө, 1979, 36). Харин дууны хуурамч хөвч, төвөнхийн булчингуудын чангаралт, сулралтаас үүсэх шахаа болон хархираа хөөмийн дуурслыг зөвхөн ам хааж хамрын хөндийгөөр дуурьсгах хэлбэр болохоос биш бусад өгүүлэх эрхтний ажиллагаа өөрчлөгдөхгүй хэвээр байхыг дараах зургаас харьцуулан харж болно (Зураг 5).



Зураг 5.

а. Монгол хэлний "м" гийгүүлэгчийг хэлэх үеийн хэлний байрлалын рентгений бүдүүвч

б. Хамрын хөөмий эгшиглүүлэх үеийн хэлний байрлалын төсөөлөл

¹⁸ МУИС-ийн "Ардын урлаг судлал" хөтөлбөрөөр суралцах үед "Хөөмий сурах арга"-ын хичээлийн явцаас хөөмийн багш Б.Одсүрэнгийн заавраар тэмдэглэж авсан зураглал. 2005 оны 10 дутаар сар

Эдгээр харьцуулалтын үр дүнгээс “а” төст авианаас шахаа хөөмий, хархираа хөөмий, үүнээс цааш салбарлан “л” төст авианаас исгэрээ хөөмий, хархираатай исгэрээ хөөмий үүсэж эдгээрийг хэл, уруулын хөдөлгөөн, булчингийн чангаралт, сулралтыг ашиглан хөөмийлөх арга барилыг янз бүрээр үүсгэж, хөгжүүлэх боломжтой хэмээн дүгнэж болохоор байна. Энэхүү үр дүнгээ монгол хэлний авиазүйн хэллэгт холбогдуулан хэлний хөдөлгөөний зураглалаар загварчлан, хөөмийн ангиллын асуудлыг системчилж харах оролдлогыг дараах байдлаар санал болгож байна (Зураг 6).



Зураг 6. Хөөмийн ангиллыг өгүүлэх эрхтний ажиглагааны үүднээс загварчлах боломж

Дээрх зураглалаар үзүүлсэн хөөмийн ангиллыг логик ойлголтын үүднээс тайлбарлавал “үндсэн шинжээрээ буюу бүтэц байгуулалтаараа ерөнхий ойлголтыг төрөл, харин бүтэц байгуулалтаараа нэгэн адил боловч оршихуйн өвөрмөц онцлогоороо ялгаатай ерөнхийн хүрээнд дэх тусгай ойлголтыг зүйл” (Балхаажав, Лувсанцэрэн, Норовсамбуу ба бус., 1990, 172) гэдэг. Онолын энэ зарчмын үүднээс хөөмийн ангиллыг тайлбарлавал шахаа хөөмийд хархираа хөөмийн шинж огт байхгүй тиймээс эдгээр нь бие даасан төрөл ойлголт болж, харин шахаа хөөмийн багалзуурт шахаж дуурьсгах ерөнхий шинж исгэрээ хөөмийд байгаа тул исгэрээ нь шахаа хөөмийн зүйл ойлголт болж таарна. Үүнтэй адил хархираа хөөмийн техникээр төвөнхийг доргиулж хэлийг иржгэр тагнай тийш байрлуулан аялгууг аялан исгэрэх боломжтой тул хархираатай исгэрээ нь “хархираа хөөмий” гэх ерөнхий ойлголтын хүрээнд зүйл ойлголт болно. Тухайлбал, исгэрээ хөөмий нь шахаа хөөмий гэх ерөнхий ойлголтын хүрээнд зүйл ойлголт, хархираатай исгэрээ, хамрын исгэрээ хөөмийн хувьд төрөл ойлголт болж таарна. Харин хамрын хөөмийн шахаа хөөмийн хувьд авч үзвэл зүйл ойлголт болох ба хамрын цуурай хөөмий болон хамрын хархираа хөөмийн хувьд төрөл ойлголт нь болно. Үүнийг дараах зургаас харж болно (Зураг 7).



Зураг 7.

а. Хамрын хөөмийн зүйл ойлголтын бүдүүвч б. Исгэрээ хөөмийн зүйл ойлголтын бүдүүвч

Хөөмийн үндсэн хоёр төрөл нь цааш задарч хэрхэн зүйлчлэгдэх боломжтойг монгол хэлний авианы аялгын төстэй шинжээр нь ялгаж, хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Шахаа болон хархираа хөөмийн зүйлчилсэн ангилал (монгол хэлний авианы аялгын хамаарлаар)

	“а” төст авиа	“л” төст авиа	“м” төст авиа		“я, ю” төст авиа	
ам	ангайна	хагас ангайна	жимийнэ	жимийнэ	ангайна	жимийнэ
хэл	доор	тагнайнд	доор	тагнайнд	доор (цохих)	доор (цохих)
Шахаа хөөмий	Шулуун шахаа	Исгэрээ	Хамрын шахаа	Хамрын исгэрээ	Үелзсэн шахаа	хамрын үелзсэн шахаа
Хархираа хөөмий	Шулуун хархираа	Хархираатай исгэрээ	Хамрын хархираа	Хамрын хархираатай исгэрээ	Үелзсэн хархираа	хамрын үелзсэн хархираа

Тэгвэл хөөмийлөх үеийн дуу авиа үүсгэх механизмыг анагаах ухааны талаас нь судалсан анатоми бүтцийн судалгааны зарим үр дүнг өөрсдийн судалгаатай харьцуулан үзвэл бидний дэвшүүлж буй хөөмийн урлаг үндсэн хоёр төрөлтэй гэсэн санаатай утга нийлж байна.

Шахаа хөөмийн дуурслын үед төвөнхийн ходоодны нугалаас нь дууны нугалаас хэсгээрээ шүргэлцэн чичирхийлж, дууны хуурамч хөвч бүх талаасаа хаагдаж нарийсан нүх болдог (Нямдорж, Энэбиш, Рэнцэндорж ба бус., 2020, 153) бол исгэрээ хөөмий нь шахаа хөөмийн үндсэн арга барил дээр зөвхөн хэлний хөдөлгөөний нөлөөгөөр таглаа мөгөөрс ихээр хөдөлдөг байна. Өөрөөр хэлбэл энэ үед төвөнхийн ходоодны нугалаас (үүдэвч)-ны дунд гуравны нэг хэсэг буюу дууны нугалаасны салст бүрхүүлүүдийн хооронд чичиргээ үүсгэснээр хөөмийн дан аялгуу буюу исгэрээ хөөмий үүсдэг байна. Харин хархираа хөөмийн дуугаралтын үе дэх дууны хуурамч хөвчийн ашиглалтын хүч шахаа хөөмийтэй харьцуулахад харьцангуй сул, дууны завсар бага зэрэг харагдаж, үечилсэн байдлаар агшилт, сулралт явагддаг байна. Өөрөөр хэлбэл энэ үед төвөнхийн ходоодны нугалаас (үүдэвч)-ны дунд урд гуравны нэг хэсэг буюу дууны нугалааснуудын хооронд

чичиргээ үүсгэснээр хархираа хөөмийн аялгуу үүсэх бөгөөд төвөнхийн ходоодны нугалаасны хойд гуравны нэг хэсгийн салст бүрхүүл чичирхийлэх боломжтой (Нямдорж, Энэбиш, Рэнцэндорж ба бус., 2020, 155) хэмээжээ.

Дүгнэлт, санал

Хөөмийн урлаг төдийгүй ардын урлагийг төрөлжүүлэн судлахдаа төрөл зүйлийн ойлголтын талаарх онолын зарчимд тулгуурлахаас гадна, салбар дундын судалгаа, түүний холбоо хамаарлыг шинжлэх нь судалгааны үр дүнд чухал ач холбогдолтойг дараах байдлаар харж байна.

- Хөөмийн ангиллыг орчин цагийн монгол хэлний авианы өгүүлүүр зүй (Articulatory Phonetics)-н үүднээс ажиглахад “а, о” [æ] бүхий авианы чуулбарын багсармал шинж нь хөөмийн анхдагч авиаг үүтгэж, шахаа болон хархираа хөөмийн дуурьсалд илүү хамааралтай байна. Харин “а-л” гэх байдлаар авиа шилжүүлэх үед исгэрээ хөөмийн хэлний байрлалд шилжих ба энэ нь “л” гийгүүлэгч авиа дангаар өгүүлэгдэхээс өөр буюу тагнайшсан шинжтэй сонсогдох тул бид исгэрээ хөөмийн өгүүлүүр зүйг “л” төст авиа буюу “лh” гэж тэмдэглэж болмоор байна.
- Хөөмийн ангиллыг логик ойлголтын үүднээс авч үзвэл “хөөмийн урлаг” гэх ерөнхий ойлголтын хүрээнд шахаа болон хархираа хөөмий нь төрөл ойлголт, харин шахаа хөөмийн багалзуурт шахаж дуурьсгах ерөнхий шинж исгэрээ хөөмийд байгаа тул исгэрээ нь шахаа хөөмийн зүйл ойлголт, хархираатай исгэрээ нь “хархираа хөөмий” гэх ерөнхий ойлголтынхоо хүрээнд зүйл ойлголт болно гэж тайлбарлаж болохоор байна.
- Харин хөөмийн үндсэн хоёр төрлийг дуурьсгахдаа хэл, уруулын булчинг чангалж суллах замаар чичиргэх, доргиулах, цохилго үүсгэх мэтээр баяжуулан дуурьсгах нь хөөмийлөх арга барилд илүүтэй хамаарах ба хэлний цохилго давамгайлсан арга барилын төрлүүдтэй орчин цагийн монгол хэлний “я”, “ё”, “ю” туслах эгшгүүдийг хамаатуулан судлах боломжтой гэж санана. Харин хөөмийн дуурслыг амаар бус хамрын хөндийгөөр гадагшлуулах явцыг “м” гийгүүлэгч авиатай харьцуулахгүй байх арга бидэнд үгүй хэмээн харж байна.
- Хөөмийн ангиллыг авиазүйн хэллэгийн үүднээс тайлбарлах оролдлого нь анагаах ухааны анатоми бүтцийн судалгааны зарим үр дүнтэй, мөн зарим судлаачдын арга, билгийн онолтой холбон судалж буй судалгааны явцын үр дүнтэй тус тус санал нэгдэж байгаа нь цаашдын судалгаанд хөөмийн ангиллын талаарх олон салаа ойлголтыг нэгтгэхэд тус дэм болох талтай хэмээн үзэж байна.

Цаашид,

- Өгүүлэх эрхтний шүтэлцээт урлагийн судалгааг зөвхөн нэг талыг барьж судлах бус физик, анагаах ухаан, сэтгэл судлалын талаас нарийвчилж, салбар дундын туршилт судалгааг гүнзгийрүүлэх, судлаачдын санааг нэгтгэх, шинэ мэдлэг бүтээх хамтын судалгаа үгүйлэгдэж байна.

- Зөвхөн өгүүлэх эрхтний шүтэлцээт урлаг буюу аман хөгжимдүүрийн урлаг төдийгүй, ардын урлагийн аливаа төрлийг ангилах, тэдгээрийн хоорондын нийтлэг ба ялгаатай талыг зөв тодорхойлох онол, арга зүйг боловсруулах, бүтэц үүргийн загварчлалыг тодорхой болгох шаардлага бидний өмнө тулгамдаж байна. Ингэхдээ Ж.Бадраагийн тэмдэглэсэн И.И.Земцовскийн ардын билгийн мөн чанарыг тодорхойлох “диалектик хослолын зарчим”, дорнын гүн ухаантан Нагаржүнийн “найман үгүйсгэлийн арга” зэргийг нягтлан үзэх шаардлагатай.

Ашигласан материалын жагсаалт

1. Бадраа, Жамц. 1998. *Монгол ардын хөгжим*. Улаанбаатар, Монгол Улс.
2. Бадраа, Жамц. 2017. *Ардын урлаг судлал: Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган*. Улаанбаатар, Монгол Улс.
3. Балхаажав, Ц., Лувсанцэрэн, Г., Норовсамбуу, С., Нямдорж, Ү., Содномгомбо, Д., 1990. *Философийн толь*. Улаанбаатар, Монгол Улс.
4. Жанцанноров, Нацаг. 1996. *Хөгжмийн онолын нэр томъёоны хураангуй тайлбар толь*. “Артикуляция”. Улаанбаатар, Монгол Улс.
5. Загд-Очир, Сумьяабазар., Даваасүрэн, Дамдинсүрэн. 2020. “Хөөмийн төрөл зүйлийн нэршлийг оновчлох асуудалд.” (Issue of optimization of terminology for the khoonii). *XIV annual Mongolina Studies Conference Art and culture among the Mongols*. February 7-9, 2020. Washington, D.C.
6. Мөөмөө, Сүрэн. 1979. *Монгол хэлний авиан зүй*. Улаанбаатар, Монгол Улс.
7. Нямдорж, Дагданбазар., Энэбиш, Сундуй., Рэнцэндорж, Цагаанхүү. ба бус. 2020. *Монгол хөөмий судлал*. Улаанбаатар, Монгол Улс: “Сэлэнгэ пресс” ХХК.
8. Одсүрэн, Баатар. 2005 оны 9-р сар. Уулзалтын тэмдэглэл.
9. Одсүрэн, Баатар. “ЮНЕСКО-гоос ирэх хариуг бүтэн жил хүлээж шаналах амаргүй байлаа” 2010.11.19. <https://gogo.mn/r/5uj2w> үзсэн: 2024.01.20. Ярилцсан: Г.Ганчимэг.
10. Отгонбаяр, Н. 2012. *Формаль логик: гарын авлага*. Улаанбаатар, Монгол Улс: БТМХХК.
11. Оюунбадрах, Баянжаргал. 2016. *Төгөлдөр хуурын зохиолыг боловсруулах асуудал*. “Хэллэг”. Улаанбаатар, Монгол Улс: “Мөрөөдлийн гурвалжин” ХХК.
12. Сандагжав, Э. 2010. *Монгол хөөмий*. Улаанбаатар, Монгол Улс: Соёмбо ХХК.
13. Санжаа, Ж., Надмид, Ж. 2008. *Монгол хэлний авиазүй ба авиалбар зүй*. Улаанбаатар, Монгол Улс.

14. Хэрлэн, Лхасүрэн. 2010. *Монгол хөөмийн утга холбогдол*. Улаанбаатар, Монгол Улс.
15. Цолоо, Жавзан. 1967. *Монгол хэлний авианы өгүүлэгдэх ёс*. Улаанбаатар, Монгол Улс.
16. Энэбиш, Жамбал. 2007. *Уран сайхны шүүмж буюу онгодыг өдөөгч халгай*. Улаанбаатар, Монгол Улс.